



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 5/16

Модот

“Залуучуудын чуулга уулзалт-2025”
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.1.2, 21.1.3 дахь заалтууд, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Сумын Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд залуучуудын нийгэмд оруулах оролцоог нэмэгдүүлэх, идэвхижүүлэх зорилгоор “Залуучуудын чуулга уулзалт-2025” зохион байгуулсугай.

2.Уг тэмцээний тусгай удирдамж боловсруулан батлуулж гүйцэтгэлийг хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын түшмэл /И.Найманцэцэг/-т даалгасугай..

3.Дээрхи арга хэмжээнд шаардагдах зардлыг Засаг даргын Тамгын газрын хөтөлбөр төслийн зардлаас 5000000 (Таван сая төгрөг)-ийг тооцож гаргахыг Санхүү албаны няглан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ